



**ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 08 сарын 26 өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

Цэвэр ашгийг хуваарилах тухай

“Компанийн тухай хууль”-ийн 6-р бүлгийн 46-р зүйл болон ТУЗ-ийн 2022 оны 08-р сарын 26-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь :

1. Компанийн 2022 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас:

- 629 914 868.02 /зургаан зуун хорин есөн сая нэг зуун арван дөрвөн мянга найман зуун жаран найман төг 02 мөнгө/ төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгаар
- 12 000 000 /арван хоёр сая төг/ төгрөгийг компанийн цалин урамшуулал, нөөцийн санд
- 83 400 416.32 /наян гурван сая дөрвөн зуун мянга дөрвөн зуун арван зургаан төгрөг 32 мөн / төгрөгийг компанийн хуримтлагдсан ашигт тус тус хуваарилсугай.

2. Компанийн 2022 оны эхний хагас жилийн хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг холбогдох хууль журмын дагуу тарааж олгохыг гүйцэтгэх захирал /Б.Оюунцэцэг/, нягтлан бодогч /О.Энхтуяа/ нарт даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Д.Туяа/-д үүрэг болгосугай.



ДАРГА

Д.ОЮУНСҮРЭН



**ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

20... оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Ногдол ашиг олгох тухай

“Компанийн тухай хууль”-ийн 46-р зүйл болон ТУЗ-ийн 2022 оны 08-р сарын 26-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь :

1. Компанийн 2022 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас хуваарилагдсан нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээг 8 төгрөг 02 мөнгөөр тогтоосугай.
2. Компанийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 09-р сарын 16-ны өдрөөр тасалбар болгосугай.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны эхний хагас жилийн ногдол ашгийг холбогдох хууль журмын дагуу 2022 оны 09-р сарын 20-ны өдрөөс эхлэн олгохыг гүйцэтгэх захирал /Б.Оюунцэцэг/, нягтлан бодогч /О.Энхтуяа/ нарт даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Д.Туяа/-д үүрэг болгосугай.



ДАРГА

Д.ОЮУНСҮРЭН



**ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 08 сарын 26 өдөр

Дугаар 9

Улаанбаатар хот

Бодлогын бичиг баримтуудыг батлах тухай

“Компанийн тухай хууль”-ийн 76.1.13-р зүйл, “Компанийн дүрэм”-ийн 7.32.11 дэх заалт болон ТУЗ-ийн 2022 оны 08-р сарын 26-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь :

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ын зарчимд нийцүүлэн компанийн дараах хөтөлбөр, бодлогын баримт бичиг, дүрэм, зааврыг хавсралтын дагуу баталсугай. Үүнд:
 - 1.1 Компанийн кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр
 - 1.2 Компанийн ёс зүйн дүрэм
 - 1.3 Компанийн залгамж халааны бодлого
 - 1.4 Компанийн цалин урамшууллын бодлого
 - 1.5 Компанийн эрсдэлийн удирдлагын заавар
 - 1.6 Компанийн дотоод хяналтын заавар
 - 1.7 Компанийн комплайнсын хяналтын заавар
2. Шинээр батлагдсан эдгээр бодлогын бичиг баримтуудыг оролцогч талуудад нээлттэй байдлаар түгээн, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг ханган ажиллахыг ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал /Б.Оюунцэцэг/, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Д.Эрдэнэсүрэн/ нарт үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Д.Туяа/-д үүрэг болгосугай.



ДАРГА

Д.ОЮУНСҮРЭН



**ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 08 сарын 26 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Журмуудыг батлах тухай

“Компанийн тухай хууль”-ийн 76.1.13-р зүйл, “Компанийн дүрэм”-ийн 7.32.11 дэх заалт болон ТУЗ-ийн 2022 оны 08-р сарын 26-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь :

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ын зарчимд нийцүүлэн компанийн дараах журмуудыг хавсралтын дагуу баталсугай. Үүнд:
 - 1.1 Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам
 - 1.2 Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны үйл ажиллагааны журам
 - 1.3 Компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам
2. Эдгээр журмуудыг баталсантай холбогдуулан 2011 оны 11-р сарын 11-ний өдрийн 10-р тогтоолын 2-р хавсралтаар баталсан “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ажиллах журам”-ыг хүчингүйд тооцсугай.
3. Батлагдсан журмуудыг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон, хэрэгжилтийг ханган ажиллахыг ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал /Б.Оюунцэцэг/ болон ТУЗ-ийн бичгийн дарга /Д.Эрдэнэсүрэн/-д үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Д.Туяа/-д үүрэг болгосугай.



ДАРГА

Д.ОЮУНСҮРЭН